


**МОНГОЛ УЛСЫН
ТҮҮХ**

2009

ХУВИЛБАР А

1. Дараах дурсгалуудын аль нь Монгол нутаг дахь хамгийн эртний урлагийн дурсгал вэ? (1 оноо)
А. Баянхонгор аймаг Баянлиг сум Цагаан агуйн дурсгал
В. Ховд аймаг Манхан сум хойд Цэнхэрийн агуйн зураг
С. Дорнод аймгийн Булган сум Норовлингийн суурин
D. Булган аймгийн Хутаг-Өндөр сум Холтост нугын дөрвөлжин булш
E. Завхан аймгийн Шилүүстэй сум Дааган дэл уулын буган хөшөө
2. Монгол нутаг дахь эртний хүмүүсийн бие бялдарын бүтцэд өөрчлөлт гарч, Орчин үеийн хүн (homo sapiens) бий болох үйл явц хэдий үед болсон бэ? (1 оноо)
А. Палеолитийн доод шат (нтө 800.000-100.000)
В. Палеолитийн дунд шат (нтө 100.000-40.000)
С. Палеолитийн дээд шат (нтө 40.000-15.000)
D. Мезолит (нтө 15.000-8.000)
E. Неолит (нтө 8.000-3.000)
3. Неолитийн үед Монгол нутаг дахь эртний хүмүүсийн ахуй амьдралд анхны зээтүүт газар тариалангийн эх үүсвэр тавигдсан боловч энэ нь далайцтай хөгжиж чадаагүй байна. Үүнд нөлөөлсөн хамгийн гол шалтгаан аль нь вэ? (3 оноо)
А. Эх газрын эрс тэс уур амьсгал
В. Мал аж ахуйг голлон эрхлэх болсон нь
С. Ан агнуурын аж ахуй голлон эрхлэх болсон нь
D. Тариалах ургамал байхгүй байсан нь
E. В ба С зөв
4. Хүрэл, төмрийн түрүү үеийн томоохон дурсгал, бие даасан соёл болох “Чандманий дурсгал” хаанабайдаг вэ? (1 оноо)
А. Ховд аймгийн Манхан сум
В. Ховд аймгийн Чандмань сум
С. Увс аймгийн Улаангом сум
D. Увс аймгийн Сагил сум
E. Баян-Өлгий аймгийн Улаан хус сум
5. Аргалийн толгойн сийлбэр бүхий энэхүү хос алтан сүлбээр Монгол улсын нутгийн хаанаас олдсон бэ? (2 оноо)



- A. Ховд аймгийн Манхан сум
- B. Увс аймгийн Улаангом сум
- C. Баян-Өлгий аймгийн Улаан хус
- D. Өвөрхангай аймгийн Богд сум
- E. Дорнод аймгийн Булган сум

6. Монгол нутаг дахь эртний хүмүүс Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеэс нүүдлийн Мал аж ахуйг голлон эрхлэх болсон нь дараах хүчин зүйлийн алинаас нь шууд хамааралтай вэ? (2 оноо)
А. Малаас гарах бүтээгдэхүүн арвин
В. Малыг адгуулахад хялбар байсан
С. Байгал цаг уурын нөхцлөөс хамаарсан
D. Газар тариалан эрхлэх боломжгүй байсан нь
E. А ба В зөв
7. Монгол нутаг дахь хадны зургийн дурсгалыг холбогдох үетэй нь тохируулна уу. (3 оноо)
 1. Ямаан усны хадны зураг
а. Чулуун зэвсгийн үеийн хадны зураг
 2. Баянлигийн хадны зураг
b. Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зураг
 3. Их тэнгэрийн амны хадны зураг
c. Сэлэнгийн зураг
 4. Чандмань хар үзүүрийн зураг
d. Эртний улсуудын үеийн зураг

А. 1- a, 2- b, 3- c, 4- d. В. 1- b, 2- a, 3- d, 4- c. С. 1- d, 2- b, 3- c, 4- a.
D. 1- b, 2- a, 3- c, 4- d. E. 1- b, 2- c, 3- a, 4- d.
8. Монгол нутаг дахь “Буган чулуун хөшөө”-г судалсан эрдэмтэд уул дурсгалыг гурав ангилсан байх бөгөөд эдгээрийн хоёр нь, 1. Бугыг загварчлан дүрсэлсэн хөшөө, 2. Амьтдын бодит дүрст хөшөө хэмээн ангилсан байдаг бол гурав дахь ангилал аль нь вэ? (2 оноо)
А. Гахай дүрсэлсэн буган хөшөө
В. Зээр дүрсэлсэн буган хөшөө
С. Янгир дүрсэлсэн буган хөшөө
D. Тамга дүрсэлсэн буган хөшөө
E. Амьтны дүрсгүй буган хөшөө

9. Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн “Хүрээ нүүдэл”-ийн зохион байгуулалтын тухай ойлголтонд аль нь багтахгүй вэ? (3 оноо)
- А. Овог, аймгийн ахлагчаа тойрон буудаг
 В. Нүүдлийн аж ахуйн зохион байгуулалтын үндсэн хэлбэр болж байв
 С. Дайсны гэнэтийн довтолгооноос хамгаалалт болдог
 D. 2-3 айл нэг хог айл болон нутагладаг
 E. Овог, аймгаараа нүүдэллэдэг
10. Хүннү гүрний хаан Модун 400 мянган морьт цэргийн хүчээр Хятадад довтлон орж Тайюань, Датун хүртэлх газар нутгийг эзэлсэн он цаг аль нь вэ? (1 оноо)
- А. НТӨ 209 он
 В. НТӨ 201 он
 С. НТӨ 198 он
 D. НТӨ 174 он
 E. НТӨ 161 он
11. 235 онд Сяньби улс задарч хэд хэдэн аймаг улс болон хуваагдсан бөгөөд дараах аймаг улсуудын аль нь тэдгээрт хамааралгүй вэ? (3 оноо)
- А. Ухуань
 В. Юйвынь
 С. Түгүхүнь
 D. Тоба
 E. Бүгд хамаарна
12. Монгол нутагт 333-555 онд эрхшээн тогтнож байсан Жужан улсын хүчирхэг үеийн дөрвөн захын хил хязгаар аль нь вэ? (3 оноо)
- А. Умар зүг Байгал нуур, өмнө зүг Цагаан хэрэм, дорно зүг Солонгос, өрнө зүг Дундад Ази
 В. Умар зүг Байгал нуур, өмнө зүг Их говь, дорно зүг Хянганы уулс, өрнө зүг Дорнод Туркестан
 С. Умар зүг Байгал нуур, өмнө зүг Их говь, дорно зүг Солонгос, өрнө зүг Хар шаар
 D. Умар зүг Байгал нуур, өмнө зүг Цагаан хэрэм, дорно зүг Солонгосын хойг, өрнө зүг Долоон усны газар
 E. Умар зүг Байгал нуур, өмнө зүг Их говь, дорно зүг Солонгос, өрнө зүг Дорнод Туркестан
13. Харьяат улс, аймаг нь байсан боловч бослого гаргаж, төр улсаа байгуулан, улмаар хүн амыг нь ихэд хядаж нэг хэсэг нь Европ тив, нөгөө нэг хэсэг нь эгц цавчим хавцалруу дүрвэн нүүдэллэж, үлдсэн цөөн хэсэг нь тэрхүү улсын харьяанд захирагдаж байсан гэвэл энд аль улсын ямар бослогын тухай ярьж байна вэ? (2 оноо)
- А. Хүннүгийн харьяанд байсан Сяньби нарын Нүүдэлчдийн бослого
 В. Сяньби улсын харьяанд байсан Жужан нарын Малчдын бослого
 С. Жужаны харьяанд байсан Түрэгүүдийн Төмөрчдийн бослого
 D. Түрэгүүдийн харьяанд байсан Уйгурчуудын Гар урчуудын бослого
 E. Уйгурын харьяанд байсан Хятан нарын Анчдын бослого
14. Монгол нутагт оршин тогтнож байсан Түрэг улсын хүн ам нь хэд хэдэн давхраанд хуваагддаг байв. Дараах хоёр баганыг зөв харгалзуулна уу. (3 оноо)
- | | |
|---------------|--------------------------------------|
| 1. Ябгу | a. Эрдэмтэн, тушаал олгогч гэж үздэг |
| 2. Шад | b. Жирийн чөлөөт иргэд |
| 3. Буюрук | c. Хааны дараа орох албан тушаал |
| 4. Тархан | d. Хааны угсааны ноёдод өгдөг |
| 5. Кара будун | e. Татвар хураагч түшмэд |
- А. 1- a, 2- b, 3- c, 4- d, 5- e.
 В. 1- b, 2- a, 3- d, 4- c, 5- e.
 С. 1- c, 2- d, 3- a, 4- e, 5- b.
 D. 1- d, 2- a, 3- b, 4- e, 5- c.
 E. 1- c, 2- e, 3- b, 4- d, 5- a.
15. Монгол нутагт эрхшээн өөрийн төрт улсаа байгуулан оршин тогтнож байсан Киргизүүдийн өвөг дээдэс хаана нутаглан суудаг байсан бэ? (2 оноо)
- А. Долоон ус
 В. Алтайн уул
 С. Тэнгэр уул
 D. Енисей мөрөн
 E. Байгал нуур
16. Монгол нутаг дахь ханлиг аймгуудаас Хөлөн, Буйр нуураар нутаглаж байсан ханлиг аймгийг нэрлэнэ үү? (1 оноо)
- А. Хамаг Монголын ханлиг
 В. Хэрэйдийн ханлиг
 С. Татарын ханлиг
 D. Найманы ханлиг
 E. Мэргэдийн ханлиг
17. “Монголын нууц товчоо”-нд гарах гурван мэргэдийг Хаад, Удуйд, Увас мэргэд гэх бөгөөд, Хаад мэргэдийг Хаатай Дармала, Удуйд мэргэдийг Тогтоа бэх захирч байсан гэвэл үлдсэн Увас мэргэдийг хэн захирч байсан бэ? (2 оноо)
- А. Чилгэр бөх
 В. Их Чилэдү
 С. Дайр үсүн
 D. Хорчи заарин
 E. Үсүн өвгөн

18. Чингис хааныг таалал болсны хойно түүний үр ач нар хаан ширээний төлөөх тэмцэлд хэрхэн хуваагдсан бэ? (3 оноо)
А. Зүчи - Цагаадайн угсаа ба Өгөөдэй - Тулуйн угсаа
В. Зүчи - Өгөөдэйн угсаа ба Цагаадай - Тулуйн угсаа
С. Зүчи - Тулуйн угсаа ба Өгөөдэй - Цагаадайн угсаа
D. Өгөөдэйн угсаа ба Зүч - Цагаадай - Тулуйн угсаа
E. Тулуйн угсаа ба Зүчи, Цагаадай, Өгөөдэйн угсаа
19. Монголын түүхэн дэх дөрвөн их хааныг өсгөн хүмүүжүүлсэн их хатан аль нь вэ? (1 оноо)
А. Есүхэй баатрын хатан Өүлэн эх
В. Өгөөдэй хааны хатан Турхана
С. Гүег хааны хатан Огула хаймиш
D. Тулуйн хатан Сорхагтан бэхич
E. Хубилай хааны хатан Чимбай
20. Хубилай хаан Монгол гүрний нийслэлийг Хятадад албан ёсоор шилжүүлэн, улсынхаа нэрийг “Юань” гэж өөрчилсөн он цаг аль нь вэ? (2 оноо)
А. 1260 он
В. 1264 он
С. 1269 он
D. 1271 он
E. 1281 он
21. Их Юан гүрний төрийн хэргийг эрхлэн явуулдаг, дотроо Сангийн, Цэргийн, Шүүх, Ёслолын, Үйлдвэрийн, Түшмэлийн гэх зургаан хэлтэстэй дотоод бичгийн хэмээх тодотгол бүхий Яам аль нь вэ? (1 оноо)
А. Шимуюан
В. Юйшитай
С. Жүншүшэн
D. Монгол журган
E. Тийм яам байгаагүй
22. Монголын түүхэн сурвалжид “Дөчин дөрвөн хоёрын төр нэгэн их хааны алдар болов” хэмээн тэмдэглэсэн нь хэн гэдэг хааны төр барьж байсан үеийг хэлж байна вэ? (2 оноо)
А. Тайсун хаан
В. Эсэн тайш хаан
С. Молон хаан
D. Батмөнх даян хаан
E. Түмэн засагт хаан
23. Монголын түүхэн сурвалж бичигүүдэд “Ухаант хаан” хэмээн алдаршсан хаан аль нь вэ? (1 оноо)
А. Мөнхтөмөр хаан
В. Тогоонтөмөр хаан
С. Доголон Төмөр хаан
D. Гүнтөмөр хаан
E. Өлзийтөмөр хаан
24. Улс төрийн бутралын үед Монголчууд Халх, Ойрад хэмээн хоёр хэсэг болон талцаж, үргэлжийн дайн самуунтай байсан бөгөөд энэхүү их дайны хөлөөр зохиогдон гарсан түүх - уран зохиолын дурсгалд аль нь хамаарах вэ? (2 оноо)
А. Тогоонтөмөр хааны гэмшил
В. Даян хааны шадар зургаан түмний магтаал
С. Хув Нагваралын тууж
D. Убаши хунтайжийн тууж
E. С ба D хариулт зөв
25. Өлзийт хунгоо бэхич хэмээх бэрийнхээ өнгөнд шунаж, улмаар Ойрадын Хутхай таяууг хилсээр хороон, дөрвөн Ойрад харь дайсан болоход нөлөө үзүүлсэн хаан аль нь вэ? (1 оноо)
А. Тогоонтөмөр хаан
В. Аюушридар хаан
С. Төгстөмөр хаан
D. Элбэг хаан
E. Гүнтөмөр хаан
26. Монголын түүхэн сурвалж бичигт, “Худгийн усыг гаргагч, Хулгар тарвагаар зулам хийгч” хэмээн Улс төрийн бутралын үеийн зүүн Монголын нэгэн түмнийг магтсан байдаг. Энэ нь аль түмэн бэ? (2 оноо)
А. Халх түмэн
В. Цахар түмэн
С. Урианхай түмэн
D. Ордос түмэн
E. Түмэд түмэн
27. Улс төрийн бутралыг даван туулахыг Эсэн тайш хаан, Батмөнх даян хаан, Түмэн засагт хаан нар оролдсон хэмээн түүхэнд үздэг бөгөөд эдгээр хаадын авч явуулсан бодлого үйл ажиллагааг тохируулна уу. (3 оноо)
1. Эсэн тайш хаан а. Гар газар, хөл хөсөр байсан үе хэмээдэг
2. Батмөнх даян хаан б. Таван ханы төв засгийн газрыг байгуулсан
3. Түмэн засагт хаан с. 1452-1455 оны хооронд хаан ор суув
А. 1а, 2б, 3с. В. 1с, 2б, 3а С. 1с, 2а, 3б
D. 1а, 2с, 3б. E. 1б, 2а, 3с
28. Түүх сударт тэмдэглэгдсэн “... Монголчууд энэ үүлтэй адил. Үүл бөөгнөрвөл бороо ордог. Монголчууд цуглавал цэрэг болно. Үүл сарнивал бороо зогсоно. Бид Монголчуудын хүчийг сарнихыг хүлээж чадвал тэднийг буулган авч чадна” гэж хэн хэлсэн бэ? (2 оноо)
А. Хан улсын жанжин Лю Бань
В. Алтан улсын хаан Баян Агуда
С. Мин улсын хаан Жу Юан Жан
D. Манжийн хаан Нурхач
E. Манжийн Тэнгэрийг тэтгэсэн хаан
29. Амарсанаа тэргүүтэй Зүүнгарын босогчид Манжийн цэрэгтэй хийсэн хамгийн сүүлчийн том тулаан ямар нэртэй газар болсон бэ? (1 оноо)
А. Цэцэг нуур
В. Шарбэл
С. Толбо нуур
D. Улаан бураа
E. Шишгид

30. Манж нар монголын шашны тэргүүн II Богд Жавзандамба хутагтыг сэм хорлон алсан хэмээдэг бөгөөд энэ нь дараах шалтгаантай. Аль нь хамааралгүй вэ? (3 оноо)
- А. Хоёрдугаар Богд 1755-1758 оны зэвсэгт тэмцлийг дэмжиж байсан
 - В. Ахыгаа Манж нарт хорлуулж алуулсанд II Богд дургуйцэж байв
 - С. II Богд Манжийн эсрэг бослого гаргахаар зэхэж байсан
 - Д. II Богд Хотогойдын Чингүнжавтай өргөн харилцаатай байсан
 - Е. Бүгд хамааралтай

31. Энэ зураг дээр байгаа хүн Манжийн эрхшээлийн үеийн эрүү шүүлтийн алинаар нь шийтгэгдсэн хүн бэ? (2 оноо)



- А. Чивчрага
- В. Туйван
- С. Мүглэн
- Д. Дөнгө
- Е. Хонгор азарга

32. Дараах зохиолуудын аль нь Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошууны хуульч Сандагийн зохиолд хамаарахгүй вэ? (2 оноо)

- А. Хаврын хайлаад урсаж байгаа цасны хэлсэн үг
- В. Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг
- С. Ботгоноос нь салгаж жинд хөлсөлсөн ингэний хэлсэн үг
- Д. Тэнгэрээс хур бороо гуйж хэлсэн нь
- Е. Сайн муу түшмэл, бичээч нарын хэлсэн нь

33. Манжийн хааны “Төмөр сүрэгчин” хэмээгдэх Дарьганга засаг захиргааны зохион байгуулалтын хувьд хаана захирагддаг байсан бэ? (2 оноо)

- А. Нийслэл хүрээний Манж сайдын газар
- В. Улиастай дахь Манж жанжны газар
- С. Өвөр монголын Манж сайдын газар
- Д. Гадаад Монголын төрийг засах явдлын яам
- Е. Цахарын хошуу захирагч гусай амбан

34. 1911 оны Үндэсний ардчилсан хувьсгалын ач холбогдлыг тоочихдоо хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)

- А. Монголын үндэсний тусгаар тогтносон төр улсыг сэргээн тунхагласан
- В. Үндэснийхээ эрхийн төлөө тэмцэх ухамсрыг төрүүлсэн
- С. Шинэ эргэлтийн бодлогыг дэлгэрүүлсэн
- Д. Соёл, эдийн засаг, улс төрийн талаар шинэтгэл хийсэн
- Е. Монголчуудын сэргэн мандалтын эхлэл болсон

35. 1911 оны 12-р сарын 29-ны өдөр билгийн тооллын ямар жилийн хэдэн сарын хэдэн бэ? (1 оноо)

- А. Улаагчин хулгана жилийн намрын адаг сарын шинийн 8
- В. Цагаагчин гахай жилийн өвлийн эхэн сарын шинийн 8
- С. Цагаагчин хулгана жилийн өвлийн дунд сарын шинийн 9
- Д. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9
- Е. Цагаан гахай жилийн өвлийн адаг сарын шинийн 8

36. Дараах түүхэн үйл явдлын өрнөсөн он цагийн аль нь буруу вэ? (3 оноо)

- А. 1911 оны VII сарын 16-н - Халхын ноёд, түшмэд нууцаар зөвлөлдөв
- В. 1911 оны VII сарын 29-н - Оросоос тусламж авах төлөөлөгчид хүрээнээс мордов
- С. 1911 оны VIII сарын 15-н - Монголын төлөөлөгчид П.Х.Столыпинтэй уулзав
- Д. 1911 оны XI сарын 20-н Халхын хүрээний бүх хэргийг түр ерөнхийлэн шийтгэх газар байгуулагдав
- Е. 1911 оны XII сарын 3-н Манж Чин улсын он тооллыг халав

37. Богд хаант Монгол улсын Засгийн Газраас 1912 онд нэгэн яамыг шинээр нэмэн байгуулсан бөгөөд энэ нь ямар Яам байсан бэ? (1 оноо)

- А. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яам
- В. Гадаад хэргийг эрхлэн шийтгэгч яам
- С. Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам
- Д. Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яам
- Е. Гаалийн хэргийг эрхлэн шийтгэх яам

38. 1912 оны 1-р сарын 21-нд ямар үйл явдал болсон бэ? (2 оноо)

- А. Манж-Хятадаас Улиастайг чөлөөлсөн
- В. Манж-Хятадаас Ховдыг чөлөөлсөн
- С. Манж-Хятадаас Дарьгангыг чөлөөлсөн
- Д. Манж-Хятадаас Шилийн гол, Цахарыг чөлөөлсөн
- Е. Манж-Хятадаас Алтайн Урианхайг чөлөөлсөн

39. Өвөр Монголыг өмгөөлөх Монгол улсын дэд сайд, бишрэлт бэйс Насан-Арвижихын удирдсан 3-р замын цэрэг аль чиглэлд хөдөлсөн бэ? (1 оноо)
А. Егүзэрийн хийдийн чиглэлд
В. Дарьгангын чиглэлд
С. Хөх хотын чиглэлд
D. Урад хошуу, Хатан голын чиглэлд
E. Сөнөдийн хоёр хошуу, Дөрвөд вангийн чиглэлд
40. 1915 онд Хиагтад болсон Монгол - Орос - Хятадын гурван улсын гэрээний эх бичиг нь үндсэн дөрвөн хэл дээр бичигдсэн байдаг. Дараах хэлний аль нь хамааралгүй вэ? (2 оноо)
А. Монгол хэл
В. Орос хэл
С. Хятад хэл
D. Англи хэл
E. Франц хэл
41. 1916-1919 онд Хүрээнд сууж байсан Хятад сайд Чен И нарын боловсруулсан “Дундад улсын засгийн газраас Гадаад Монголыг хүндэтгэх ба жич хойчийг сайжруулах хууль зүйл” буюу “Гадаад Монголын хойчийг сайжруулах 64 зүйл” хэмээх гэрээний агуулгад аль нь хамааралтай вэ? (2 оноо)
А. Монголд Хятад цэргийг оруулах
В. Монгол дахь Оросын нөлөөг бууруулах
С. Монголын автономийг устгаж Хятадад нэгтгэх
D. Монголын ирээдүй хойчийг сайжруулах
E. А, В, С хариулт зөв
42. 1921 оны III сарын 10-нд хийсэн зохион байгуулалтаар Ардын журамт цэргийн анхны дөрвөн хороог байгуулан, энэхүү дөрвөн хороог нэг, нэг хүнээр захируулсан байна. Дараах хүмүүсээс хэн нь дөрвөн хорооны даргад хамааралгүй вэ? (3 оноо)
А. Б.Пунцаг
В. О.Цэрэндорж
С. Ц.Хасбаатар
D. Ч.Базарсад
E. Ц.Дамбадорж
43. Дараах өгөгдлүүдийг холбогдох он цагтай нь харгалзуулна уу? (3 оноо)
Нийслэлийн сонин бичиг a. 1990
Нийслэл хүрээний сонин бичиг b. 1960
Монгол үгийн бодрол c. 1915
Намын амьдрал d. 1908-1909
Үг e. 1923-1924
А. 1e, 2c, 3d, 4b, 5a
В. 1a, 2d, 3e, 4c, 5b
С. 1d, 2a, 3c, 4e, 5b
D. 1e, 2c, 3a, 4d, 5b
E. 1d, 2e, 3b, 4a, 5c
44. 1924 оны XI сарын 26-ны өдөр баталсан Анхдугаар үндсэн хуулийн төслийг боловсруулахад Оросын талаас хамгийн гол үүрэг гүйцэтгэсэн мэргэжилтэн хэн бэ? (2 оноо)
А. Т.Рыскулов
В. Э.Ринчино
С. Ц.Жамсрано
D. П.Всесвятский
E. М.И.Амугаев
45. Зүүнтний бодлого Монголд хэрэгжээний үр дагаварт аль нь хамааралгүй вэ? (1 оноо)
А. Зөвхөн ядуу доорд ардыг дэмжиж, ялгаварлан гадуурхсан
В. Баячуудын хөрөнгийг хураасан
С. Зэвсэгт бослого гарсан
D. Энгийн нэгдлүүдийг байгуулсан
E. Хамтралуудыг олноор байгуулсан
46. 1931 онд засаг захиргааны зохион байгуулалтанд томоохон өөрчлөлт хийсэн бөгөөд энэхүү өөрчлөлтөөр бий болсон засаг захиргааны нэгжийн дараалал аль нь вэ? (3 оноо)
А. Аймаг, Хошуу, Сум, Баг
В. Аймаг, Хошуу, Сум
С. Аймаг, Сум, Баг
D. Аймаг, Сум, Бригад
E. Аймаг, Сум, Хошуу
47. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр заасан арга хэмжээнүүдэд хамааралгүй зүйл аль нь вэ? (2 оноо)
А. АЗГ-ыг бэхжүүлэх, үндэсний ардчилсан үзлийг чиг баримжаа болгох
В. Хамтралуудыг татан буулгах, энгийн нэгдлүүдийг байгуулах
С. Хувийн хөдөлмөр, худалдааг зогсоох
D. Улс хоршооллын газруудад банкны зээл олгох
E. Шашин шүтлэгийг чөлөөтэй болгох
48. 1937-1939 оны Их хэлмэгдүүлэлт нь Монголын түүхэнд томоохон сургамж үлдээсэн түүхэн үйл явдал билээ. Энэ үйл явдал өрнөх болсон хамгийн гол шалтгаан аль нь вэ? (3 оноо)
А. Коминтерн, ЗОУ-ын эрх баригчид төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх үүднээс
В. Х.Чойбалсан төрийн бүхий л эрх мэдлийг гартаа авах гэж
С. И.Сталин хувьсгалыг эсэргүүцсэн монголчуудаас хариугаа авах гэж
D. Их гүрнүүдийн сонирхлын мөргөлдөөн, геополитикийн бодлогын үүднээс
E. Монголын засгийн газрыг хяналтандаа байлгахын тулд

49. 1990 оны ардчилсан хувьсгалын ач холбогдлыг тоочихдоо хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
- А. Авторитар дэглэм нурж, төрийн ардчилсан тогтолцоо бий болсон
 В. Олон ургалч үзлийг цаашид төлөвшүүлэх нөхцлийг бүрдүүлсэн
 С. Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлсэн
 Д. Төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэн
 Е. МАХН, АН гэсэн 2 намын тогтолцоо бий болсон
50. Монгол улсын Ерөнхий сайдуудын зөв дараалалд байгаа нь аль нь вэ? (3 оноо)
- А. ПЖасрай, Д.Бямбасүрэн, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт
 В. Д.Бямбасүрэн, ПЖасрай, М.Энхсайхан, Н.Энхбаяр
 С. М.Энхсайхан, Ц.Элбэгдорж, Ж.Наранцацралт, Р.Амаржаргал
 Д. ПЖасрай, М.Энхсайхан, Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж
 Е. Д.Бямбасүрэн, П.Жасрай, Ж.Наранцацралт, Н.Энхбаяр

ХУВИЛБАР С

1. Монгол нутагт 500.000 жилийн тэртээ хүн оршин амьдарч байсныг илтгэх түүхийн дурсгал аль нь вэ? (2 оноо)
- А. Баянхонгор аймаг Баянлиг сум Цагаан агуйн дурсгал
 В. Баянхонгор аймгийн Өлзийт сум Уранхайрхан
 С. Дундговь аймгийн Гурвансайхан сум Ярх уул
 Д. Дорнод аймгийн Булган сум Норовлин уул
 Е. Ховд аймгийн Алтай сум Барлагийн гол
2. Ховд аймгийн Манхан сумын нутагт орших хойд Цэнхэрийн агуйн хадны зураг дараах ангиллын алинд нь багтах вэ? (1 оноо)
- А. Бодит байдлаар дүрсэлсэн зосон зураг
 В. Зураагийн улаан хадны төрлийн зураг
 С. Бодит байдлаар дүрсэлсэн сийлмэл зураг
 Д. Загварчлан дүрсэлсэн сийлмэл зураг
 Е. Ямарваа нэгэн ангилалд хамаардаггүй
3. Аль нь хуучин чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн эрхэлж байсан гол аж ахуй вэ? (2 оноо)
- А. Ангийн аж ахуй
 В. Үр үндэс түүх аж ахуй
 С. Мал аж ахуй
 Д. Газар тариалан
 Е. А ба В хариулт зөв
4. Чулуун зэвсгийн үеийн урлагт ан амьтдыг дүрслэхдээ хэрэглэдэг гэдэснийх нь доор зурсан “Зууван дугуй” дүрсийг судлаачид хэрхэн тайлбарладаг вэ? (3 оноо)
- А. Гэршүүлсэн амьтан болохыг нь илэрхийлсэн тэмдэг
 В. Зэрлэг амьтан болохыг нь илэрхийлсэн тэмдэг
 С. Үр төлтэй, эм амьтан болохыг нь илэрхийлсэн тэмдэг
 Д. Үржлийг бэлгэдсэн тэмдэг
 Е. Ямарваа нэгэн тайлбар байхгүй
5. Дараах дурсгалуудын аль нь чулуун зэвсгийн үеийн хадны зурагт багтахгүй вэ? (2 оноо)
- А. Ховд аймаг Манхан сумын Хойт цэнхэрийн агуй
 В. Хэнтий аймаг Биндэр сумын Бичигт хадны зураг
 С. Увс аймаг Сагил сумын Могоогийн хадны зураг
 Д. Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын Цагаан салаагийн хадны зураг
 Е. Бүгд багтана
6. Энэхүү чулуун онго Монгол нутгийн хаанаас олдсон бэ? (2 оноо)



- А. Баянхонгор аймгийн Баянлиг сум Цагаан агуй
 В. Баянхонгор аймгийн Өлзийт сум Уранхайрхан
 С. Дундговь аймгийн Гурвансайхан сум Ярх уул
 Д. Дорнод аймгийн Булган сум Норовлин уул
 Е. Дорнод аймгийн Халх гол сум Хэрээ уул

7. Монгол нутаг дахь Дөрвөлжин булшийг зан үйл, ёслолын зориулалтаар нь хоёр ангилдаг. Аль нь зөв хариулт вэ? (3 оноо)
- А. Дөрвөн буландаа өндөр шонтой, Дөрвөн өнцөгт хүрээтэй
 В. Дөрвөн талын хүрээ нь нам, Хавтгай чулуун дараастай
 С. Дөрвөн талдаа хүрээ чулуутай, Урд хашлага нь хонхойсон
 Д. Оршуулах ёслолын, Тахилга ёслолын байгууламжтай
 Е. Хойлго үйлдсэн шинж тэмдэгтэй, Хойлго үйлдсэн шинж тэмдэггүй

8. Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн дурсгал болох Чандмань уулын булшны эзэд хэдий үед Монгол оронд амьдарч байсан бэ? (1 оноо)
А. НТӨ II мянган жил В. НТӨ VIII-VII зуун С. НТӨ VII-III зуун
D. НТӨ II-I зуун E. НТ III-VII зуун
9. Ариун Ромын эзэнт гүрэн мөхөхөд нөлөө үзүүлсэн, дэлхийн түүхэнд “Тэнгэрийн ташуур” хэмээн алдаршсан Атилл хаан угсаа гарвалын хувьд аль улсад хамаарах вэ? (2 оноо)
А. Хүннү гүрэн В. Сяньби улс С. Жужан улс
D. Түрэг улс E. Хятан гүрэн
10. Дараах урлагийн дурсгалаас алийг нь Хүннү гүрний үед холбогдуулан үздэг вэ? (1 оноо)
А. Ховд аймгийн Манхан сумын нутаг Ишгэн толгойн хадны зураг
B. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг Хар хадны зураг
C. Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан усны хадны зураг
D. Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Тэвшийн хадны зураг
E. Улаанбаатар хотын ойр орших Их тэнгэрийн амны хадны зураг
11. Дараах аймгуудын аль нь Дунхугийн холбоонд багтахгүй вэ? (3 оноо)
А. Ухуань аймаг В. Муюн аймаг С. Тоба аймаг
D. Түгүхүн аймаг E. Бүгд багтана
12. Энэ үеийн хүн чулуу нь “... хоёр гараараа хэвлийн өмнө сав барьсан, босоо дүрстэй, хоёр чихэвчийг нь дээш сөхсөн дүрэг малгайтай, олон унжлага зүүлт бүхий бүстэй” байдаг бол энд хэдий үед холбогдох хүн чулууны тухай өгүүлж байна вэ? (2 оноо)
А. Түрэгийн үеийн Хүн чулуу В. Уйгурын үеийн Хүн чулуу
C. Хятан гүрний үеийн Хүн чулуу D. Монгол гүрний үеийн Хүн чулуу
E. Ийм дүрслэлтэй хүн чулуу байхгүй
13. Монгол нутаг дахь эртний улсуудын түүхэнд холбогдох он цагийг тохируулна уу. (3 оноо)
1. 552 он а. Киргизийн хаант улс байгуулагдав
2. 590 он b. Ордубалык хотыг байгуулав
3. 751 он c. Түрэгийн хаант улс байгуулагдав
4. 840 он d. Елюй Амбагян хаан суув
5. 901 он e. Түрэг улс баруун зүүн хоёр хэсэгт хуваагдав
A. 1a, 2b, 3c, 4d, 5e B. 1c, 2e, 3b, 4a, 5d C. 1d, 2a, 3c, 4b, 5e
D. 1d, 2a, 3b, 4c, 5e E. 1c, 2a, 3b, 4d, 5e
14. Дараах саналуудын аль нь Монгол хэмээх нэрний тухай судалгаанд хамааралгүй вэ? (3 оноо)
А. Модуны нэртэй холбон тайлбарладаг
B. Мугулюйн нэртэй холбон тайлбарладаг
C. Хятад сурвалжид Мэнгу хэмээн тэмдэглэсэн
D. Монгол нутагт байсан язгуур аймгийн нэрнээс үүссэн
E. XII-XIII зууны үеэс төлөвшин тогтсон
15. Монгол угсааны Хятан улс нь хэдэн оноос эхлэн улсаа Их Ляо гүрэн хэмээн нэрийдэх болсон бэ? (1 оноо)
A. 901 он B. 917 он C. 936 он D. 946 он E. 1125 он
16. Хамаг монголын Тэмүжин, Хэрэйдийн ван хан Тоорил, Жадаран аймгийн Жамуха сэцэн нарын хамтарсан цэрэг 1179 онд Мэргэдийг дайлж, Тэмүжиний хатан Бөртийг буцаан авчирсан бөгөөд энэхүү тулалдааныг түүхэнд хэрхэн нэрийддэг вэ? (1 оноо)
А. Буур хээрийн тулалдаан В. Муу өндөрийн тулалдаан С. Хүйтэний тулалдаан
D. Наху гүний тулалдаан E. Сайр хээрийн тулалдаан
17. “Монголын нууц товчоо”-нд Өэлүн эх, “... Ханиа барагсад, Харвисаа хазах хасар нохой мэт, Сүүдрээс өөр нөхөр үгүйд, Сүүлнээс өөр ташуур үгүйд” гэхчилэн хэнийг, юуны учир зэмлэдэг вэ? (2 оноо)
А. Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг хороолоо хэмээн
B. Тэмүжинг Жамухаас хагацан нүүв гэж
C. Тэмүжинг Хасарыг буруутган байцаасан гэж
D. Тэмүжинг Тоорил ханаас нүүр буруулах болов гэж
E. Өэлүн эх тийм үг хэлээгүй
18. Чингис хаан нийтийн тооллын онд, одоогийн аймгийн сумын багийн нутаг, тэр үеийн хэмээх нэртэй газар төржээ. (2 оноо)
A. 1162 он, Хэнтий аймаг, Дадал сум, Гурван нуур багийн нутаг, Болдогийн толгой
B. 1162 он, Хэнтий аймаг, Дадал сум, Гурван нуур багийн нутаг, Дэлүүн болдог
C. 1162 он, Хэнтий аймаг, Дадал сум, Баян нуур багийн нутаг, Дэлүүн болдог
D. 1163 он, Хэнтий аймаг, Дадал сум, Гурван нуур багийн нутаг, Дэлүүн болдог
E. 1163 он, Хэнтий аймаг, Дадал сум, Баян нуур багийн нутаг, Болдогийн толгой

19. "... Тэнгэрийн байдал дулаарах тийшээ хандлаа. Эмил нутгийн уур амьсгал надад зохидог юм. Тэндхийн ус умдаа өвчинд минь тус болно" гэж хэн хэлсэн бэ? (1 оноо)
 А. Чингис хаан В. Өгөөдэй хаан С. Гүюг хаан
 D. Бат хаан E. Хубилай хаан
20. Их Монгол улсын нийслэл Хар Хорум хотод байсан "Мөнгөн мод" -ыг дараах хүмүүсээс хэн нь урласан бэ? (2 оноо)
 А. Плано Карпини В. Гилиом де Рубрук С. Вильгелм де Бушь
 D. Марко Поло E. Рашид-Ад-Дин
21. "Монголын нууц товчоо"-г олон арван жил судлан шинжээд "... Халцгай цөлд ганц өндөр нарс ургадаггүй, өндөр нарс их ойн дунд өндөр, нам олон нарсны зэргэлдээ ургадаг биш үү. Тэрчлэн өндөр сайхан нарс мэт сүндэрлэсэн Нууц товчоо гэдэг зохиол бол тэр цагт байсан яруу сайхан олон зохиолын нэг мөн гэж бодож болно." хэмээн хэлсэн эрдэмтэн аль нь вэ? (3 оноо)
 А. Ц.Дамдинсүрэн В. Д.Цэрэнсодном С. Б.Сумъяабаатар
 D. Ш.Бира E. Ш.Чоймаа
22. Их Юан гүрний үед өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрийг хэрхэн нэрийдэж байсан бэ? (2 оноо)
 А. Уугуул монгол нутаг В. Арын Юан С. Ар Юан
 D. Умард Юан E. Давааны арын орон
23. Улс төрийн бутралын үеийн хаадыг төр барьж байсан он цагтай нь тохируулна уу. (3 оноо)
 1. Билэгт хаан a. 1393-1399 он
 2. Гүнтөмөр хаан b. 1399-1402 он
 3. Усгал хаан c. 1370-1378 он
 4. Элбэг хаан d. 1378-1388 он
 5. Энхзоригт хаан e. 1388-1393 он
 А. 1a, 2b, 3c, 4d, 5e В. 1c, 2a, 3d, 4b, 5e С. 1d, 2a, 3c, 4b, 5e
 D. 1d, 2a, 3b, 4c, 5e E. 1c, 2b, 3d, 4a, 5e
24. Тайсун хаан, Эсэн тайш нар онд Хятадад дөрвөн замын их цэргээр довтлон орж Хятадын эзэн хаан -ыг олзлон авч байжээ. Энэ нь түүхэнд хэмээн тэмдэглэгдсэн байна. Аль нь зөв хариулт вэ? (2 оноо)
 А. 1447 он, Ван Жэнь хаан, Тумогийн хэрэг В. 1448 он, Ин Зун хаан, Тумогийн явдал
 С. 1449 он, Ин Зун хаан, Тумогийн хэрэг D. 1450 он, Жүн Түн хаан, Тумогийн хэрэг
 E. 1451 он, Жүн Түн хаан, Датуны хэрэг
25. Одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Хөх хотыг анх хэн санаачлан байгуулсан бэ? (1 оноо)
 А. Түмэн засагт хаан В. Лигдэн хутагт хаан
 С. Халхын Цогт хунтайж D. Ордос аймгийн Хутагтай сэцэн хунтайж
 E. Түмэд аймгийн Алтан хан Ананд
26. Дараах өгөгдлүүдийг харгалзуулна уу? (3 оноо)
 1. Өгөөдэй хаан a. Үлэмж жаргалангаар хүн амьтныг тэтгэж байсан
 2. Хубилай хаан b. Гар газар, хөл хөсөр болов
 3. Эсэн тайш хаан c. Их хуралдайгаар хаан сонгох журмыг эвдэж 1260 онд өөрөө хаан суув
 4. Батмөнх даян хаан d. Хөлийг нь хөсөр, гарыг нь газар тавиулж жаргаая
 5. Түмэн засагт хаан e. Эцгийн тайш цолыг залгамжлан улмаар хаан суув
 А. 1b, 2d, 3e, 4a, 5c В. 1d, 2c, 3e, 4b, 5a С. 1a, 2b, 3d, 4c, 5e
 D. 1c, 2e, 3a, 4d, 5b E. 1e, 2c, 3a, 4b, 5d
27. Монгол оронд түгэн дэлгэрсэн шарын шашны Монголчуудын амьдралд үзүүлсэн сөрөг нөлөөлөлд аль нь хамаарахгүй хариулт вэ? (2 оноо)
 А. Хүн амын нөхөн үйлдвэрлэл саарсан
 В. Үндэсний бичиг соёлын хөгжил саарсан
 С. Эдийн засгийн хөгжилт саарсан
 D. Үндэсний түүх, уран зохиолын ном гар бичмэлээр хуулахаар хязгаарлагдаж байв
 E. Шашны ном барлах хэвлэх ажилд ахиц гарав
28. Монголчууд ээлж дараалан Манж Чин гүрний эрхшээлд орсон нь Монголчуудын амьдралд ямар сөрөг нөлөө хамгийн их үзүүлсэн бэ? (3 оноо)
 А. Хоцрогдсон бөглүү нутаг болж хувирсан
 В. Орос улстай харилцах боломжгүй болсон
 С. Монголчууд Манж, Хятадад уусахаас сэргийлсэн
 D. Нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилт нь саарсан
 E. А ба D хариулт зөв

29. Дараах хууль эрхэмжийн бичгүүдээс аль нь Манжийн эрхшээлийн үед хамааралгүй вэ? (1 оноо)
А. Халх Журам
В. Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг
С. Шавь яамны улаан хацарт
D. Хугархай нүүрт хуучин журамлах данс
E. Дөчин дөрвөн хоёрын Их цааз
30. Дараах хариултуудын аль нь Манжийн эрхшээлийн үеийн монголын “Хэтэрхий дөрвөн хэргэмтэн”- д багтахгүй вэ? (2 оноо)
А. Ван В. Бэйл С. Бэйс D. Гүн E. Тайж
31. Монгол оронд худалдаа хийх тусгай зөвшөөрлийн бичиг (пяо)-ийг хятад худалдаачид нэг жилийн хугацаатай авдаг байсан бөгөөд дараах газруудын хаанаас авдаг байсан бэ? (2 оноо)
А. Гадаад Монголын төрийг засах явдлын яам
В. Нийслэл хүрээний Манж сайдын газар
С. Улиастай дахь Манж жанжны газар
D. Ховд дахь Манж сайдын газар
E. Тийм зөвшөөрлийн бичиг байгаагүй
32. Манжийн эрхшээлийн үеийн монголын харуулын албыг гүйцэтгэж байсан ажил үүрэгтэй нь тохируулна уу. (3 оноо)
- | | |
|------------------|-------------------------------|
| 1. Суман харуул | a. Цагдаагийн үүрэгтэй |
| 2. Гэр харуул | b. Говь орчмын харуул |
| 3. Дотуур харуул | c. Эхнэр хүүхдийн хамт хашдаг |
| 4. Алтан харуул | d. Эр цэргийн алба юм |
- А. 1a, 2b, 3c, 4d В. 1d, 2c, 3a, 4b С. 1d, 2a, 3c, 4b
D. 1d, 2a, 3b, 4c E. 1c, 2a, 3b, 4d
33. Монголчуудаас Манж нарт залгуулж байсан “Есөн цагааны алба”-нд аль нь багтах вэ? (2 оноо)
А. Дөрвөн цагаан морь, Таван цагаан тэмээ
В. Таван цагаан морь, Дөрвөн цагаан тэмээ
С. Зургаан цагаан морь, Гурван цагаан тэмээ
D. Долоон цагаан морь, Хоёр цагаан тэмээ
E. Найман цагаан морь, Нэг цагаан тэмээ
34. Богд хаант Монгол улсын парламент болох Улсын дээд, доод хурал хэдэн онд байгуулагдсан бэ? (1 оноо)
А. 1911 он В. 1912 он С. 1913 он
D. 1914 он E. 1915 он
35. 1919 онд Монголын автономийг устгасан хэрэг явдал Монгол оронд дараах нөхцөл байдлыг бий болгосон байна. Аль хариулт нь хамааралтай вэ? (1 оноо)
А. Монголд хятад цэрэг орж ирэх нөхцөл бий болсон
В. VIII богдын хэмжээгүй эрх сэргэсэн
С. Монголын автономит эрх устсан
D. Монголын ирээдүй хойчийг сайжруулсан
E. А ба С хариулт зөв
36. Монгол оронд цагаан цэрэг удирдан орж ирсэн хүмүүсийн нэрийг дурьдахдаа хамааралгүй хүн оруулсан гэвэл аль нь вэ? (1 оноо)
А. Кайгородов В. Бакич С. Байкалов
D. Казанцев E. Резухин
37. Дараах өгөгдлийг харгалзуулна уу? (3 оноо)
- | | |
|--|-----------------|
| 1. Хиагтын зүүнтэйх нутгаас элссэн цэрэг | a. Хошуу цэрэг |
| 2. Эрдэнэ вангийн хошуунаас элссэн цэрэг | b. Шадар цэрэг |
| 3. Сумьяа бэйсийн хошуунаас элссэн цэрэг | c. Цоохор цэрэг |
| 4. Бусад нутгаас элссэн цэрэг | d. Цахар цэрэг |
- А. 1a, 2b, 3d, 4c В. 1b, 2a, 3d, 4c С. 1c, 2d, 3b, 4a
D. 1d, 2c, 3a, 4b E. 1a, 2c, 3b, 4d
38. 1921 оны 11-р сарын 1-нд Ардын засгийн газраас “Тангарагийн гэрээ”-г юуны учир батлан гаргасан бэ? (1 оноо)
А. Ардын засгийн газар ба Богд хааны хоорондын харилцааг зохицуулах
В. Ардын журамт цэргийг зохион байгуулах
С. Харийн цэргийн дарлалыг устгахын тулд
D. Богд хааныг хаан ширээнээс буулгахын тулд
E. Монгол ардын намын гишүүд дагаж мөрдөх

39. Судар бичгийн хүрээлэн дараах он цагийн алинд нь байгуулагдсан бэ? (2 оноо)
 А. 1920 оны XI сар В. 1921 оны XI сар С. 1922 оны XI сар
 D. 1923 оны XI сар E. 1924 оны XI сар
40. Дараах түүхэн үйл явдал болж өнгөрсөн он цагийн аль нь зөв бэ? (3 оноо)
 А. 1921 оны 3-р сарын 11-н - МАН байгуулагдав
 В. 1920 оны 3-р сарын 13-н - Ардын түр засгийн газар байгуулагдав
 С. 1921 оны 3-р сарын 15-н - Хиагтыг гамин цэргээс чөлөөлөв
 D. 1921 оны 7-р сарын 11-н - Монгол, Орос цэргүүд Нийслэл хүрээнд орж ирэв
 E. С ба D хариулт зөв
41. 1923 оноос аймаг хошуудын хуучин нэрийг халан, газар усны нэрээр нэрлэх болсон байна. Энэ үед хуучны Халхын Сэцэн хан аймгийг хэрхэн нэрийдэх болсон бэ? (1 оноо)
 А. Хан Хэнтий уулын аймаг В. Богд хан уулын аймаг
 С. Цэцэрлэг мандал уулын аймаг D. Хантайшир уулын аймаг
 E. Чандмань уулын аймаг
42. Ардын засгийн газраас батлан гаргасан эрх зүйн баримтуудад аль нь хамааралгүй вэ? (3 оноо)
 А. Засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм
 В. Жинхэнэ дагаж мөрдөх хууль дүрэм
 С. Их шавийн захиргааны дүрэм
 D. Ховдын харьяат газрын захиргааны дүрэм
 E. Монгол улсын нутгийн захиргааны дүрэм
43. Дараах зүтгэлтнүүдийн хэн нь Монголын эдийн засгийг өөд нь татахын тулд хувийн аж ахуйтныг дэмжих хэрэгтэй хэмээн үзэж, улмаар “баяжихтун” хэмээх уриа гаргаж, Баруунтан хэмээгдэн цаазлуулсан бэ? (1 оноо)
 А. Д.Бодоо В. С.Данзан С. С.Дамдинбазар
 D. Б.Цэрэндорж E. А.Амар
44. Монгол дахь Зүүнтний бодлогын хор уршиг, алдааг дурьдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
 А. ЗХУ-ын заавар зөвлөлгөөг шууд дагасан В. Чинээлэг ардыг бүх талаар хавчсан
 С. Хувийн өмч ба хөдөлмөрийг үйгүйсгэсэн D. Шашин шүтлэгийг хорьсон
 E. Энгийн худалдааг дэмжсэн
45. 1931 оны Засаг захиргааны зохион байгуулалтаар 13 аймгийг шинээр байгуулсан бөгөөд дараах аймгуудын аль нь 1931 онд байгуулагдаагүй вэ? (2 оноо)
 А. Архангай аймаг В. Дорнод аймаг С. Завхан аймаг
 D. Сүхбаатар аймаг E. Тариалан аймаг
46. Малыг албадан нийгэмчилсний сөрөг үр дагаварт аль нь хамаарахгүй вэ? (3 оноо)
 А. Малчдаас үйлдвэрлэлийн хэрэгслийг нь салгаснаар тэд малаа өсгөх, хөдөлмөрлөх сонирхол буурсан
 В. Малчид нэгдэлд орохоос урьтаж малаа нядлах, зарж борлуулах болсноор мал сүрэг хорогдсон
 С. Айл саахалтаараа хамтран мал маллах арга утсан
 D. Хувийн өмчийг нь хүчээр нийгэмчилснээр малчид өрх гэртээ бус улсад хөлсөөр ажиллах сонирхол их болсон
 E. Мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг эрс өөрчилсөн
47. БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1956 оны XII сарын 31-ний өдрийн 234-р зарлигаар “БНМАУ-ын хөдөлмөрийн баатар” хэмээх цол, тэмдгийг бий болгож эх орноо хөгжүүлэх, бүтээн байгуулах үйлст гарамгай хувь нэмэр оруулсан хүмүүст олгох болсон бөгөөд, энэхүү цол тэмдгийг хамгийн анх хүртсэн хүн аль нь вэ? (2 оноо)
 А. Илчит тэрэгний машинист Л.Ойдовням В. Уурхайн бэхлэгч-малтагч Д.Даваажав
 С. Хоньчин баатар С.Цогтгэрэл D. Нэхмэлчин баатар Ц.Гүнжинлхам
 E. Ямаачин баатар Т.Жамц
48. 1960 онд хуралдсан БНМАУ-ын АИХ-ын 4 дэх удаагийн чуулганаар АИХ-ын тэргүүлэгчдийн даргаар хэнийг сонгосон бэ? (1 оноо)
 А. Х.Чойбалсан В. Ю.Цэдэнбал С. Ж.Самбуу
 D. Г.Бумцэнд E. Ж.Батмөнх
49. Түүхэн үйл явдлуудыг зөв дараалалд оруулна уу. (3 оноо)
 1. БНМАУ НҮБ-д гишүүнээр элссэн 2. Ж.Гүррагчаа сансарт нисэв
 3. Л.Энэбиш УИХ-ын дарга болов 4. БНМАУ-ын VIII их хурал хуралдав
 5. Н.Багабанди МУ-ын хоёр дахь ерөнхийлөгчөөр сонгогдов.
 А. 1, 2, 3, 4, 5. В. 2, 4, 3, 5, 1. С. 4, 1, 2, 5, 3.
 D. 5, 4, 1, 3, 2. E. 3, 5, 2, 1, 4.

50. МАХН-ын VIII бүгд хурал хуралдаж, Улс төрийн товчоо бүрэлдэхүүнээрээ огцрох шийдвэр гаргасан он цагт аль нь хамааралтай вэ? (2 оноо)
- A. 1989 оны XII сар В. 1990 оны III сар С. 1991 оны I сар
D. 1992 оны I сар E. 1993 оны I сар

ХУВИЛБАР Е

1. Дараах дурсгалуудын аль нь Монгол нутаг дахь хамгийн эрт үед холбогдох түүхийн дурсгал вэ? (3 оноо)
- A. Эртний хүмүүсийн амьдарч байсан Бууц суурин
B. Эртний хүмүүсийн үлдээсэн Булш оршуулга
C. Эртний хүмүүсийн үлдээсэн Хадны зураг
D. Эртний хүмүүсийн амьдарч байсан Хот суурин
E. Эртний хүмүүсийн үлдээсэн Буган хөшөө
2. Чулуун зэвсгийн үеийн хүмүүс “Сөрөгт ясан жад”-ыг ямар зориулалтаар хэрэглэдэг байсан бэ? (1 оноо)
- A. Том амьтдыз агнах зорирлалтаар
B. Жижиг амьтдыз агнах зориулалтаар
C. Загас агнах зориулалтаар
D. Аж ахуйн зориулалтаар
E. Гоёл чимэглэлийн зориулалтаар
3. Монголын чулуун зэвсгийн үеийн урлагийн хамгийн гол дүрслэл аль нь вэ? (2 оноо)
- A. Ан гөрөө, нум сум В. Амьтны дүр С. Эх хүн
D. Ахуй амьдрал E. Дөрвөлжин хүрээ, олон цэг
4. Дараах түүхийн дурсгалыг орших газар нутагтай нь тохируулна уу. (3 оноо)
1. Зуухын суурин а. Увс аймгийн Сагил сум
2. Моожоогийн хадны зураг б. Ховд аймгийн Буянт сум
3. Чандмань хар үзүүрийн зураг с. Дорнод аймгийн Булган сум
4. Рашаан хадны зураг d. Баянхонгор аймгийн Баянлиг сум
5. Норовлингийн суурин e. Хэнтий аймгийн Батширээт сум
- A. 1- d, 2- a, 3- b, 4- e, 5- c В. 1-а, 2-д, 3-е, 4-с, 5-б. С. 1-б, 2-а, 3-д, 4-е, 5-с.
D. 1- e, 2- b, 3- c, 4- d, 5-а E. 1-д, 2-с, 3-е, 4-а, 5-б.
5. Монголын түүхэн дэх Энеолитийн үе гэдэг нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ? (1 оноо)
- A. Хуучин чулуун зэвсгийн үе В. Дунд чулуун зэвсгийн үе
C. Шинэ чулуун зэвсгийн үе D. Зэс чулуун зэвсгийн үе
E. Хүрэл зэвсгийн үе
6. Энэхүү хадны зураг Монгол улсын нутгийн хаанаас олдсон дурсгал вэ? (2 оноо)



- A. Ховд аймаг Манхан сум Ишгэн толгой
B. Ховд аймаг Эрдэнэбүрэн сум Хар хад
C. Ховд аймаг Үенч сум Ямаан ус
D. Өвөрхангай аймаг Богд сум Тэвш уул
E. Улаанбаатар хотын ойр орших Их тэнгэрийн ам

7. Дараах дурсгалуудыг холбогдох онцлог шинжтэй нь тохируулна уу. (3 оноо)
1. Хадны зураг а. Баруун бүс нутгаар тархсан
2. Буган чулуун хөшөө б. Сэлэнгийн хэмээн тодотгодог
3. Дөрвөлжин булш с. 30 гаруй хэлбэр дүрстэй, чулуун дараастай
4. Түүвэр олдвор d. Байлдааны, Аж ахуйн гэж ангилдаг
5. Хиригсүүрийн соёл e. Оршуулга болон тахилгын байгууламжтай
- A. 1a, 2b, 3c, 4d, 5e В. 1b, 2a, 3e, 4c, 5d С. 1b, 2a, 3d, 4e, 5c
D. 1b, 2a, 3e, 4d, 5c E. 1b, 2e, 3a, 4d, 5c
8. “Үргэлжийн салхитай байдаг уулын онь хөтөл дээр галлах амыг нь салхи өөд харуулсан зуух барьж, түүнд илч ихтэй түлш хийн, тэр түлш дээрээ төмрийн хүдэр овоолоод гал оруулж төмөр хайлан авна.” Энэ төмөрлөг боловсруулалтын ямар арга вэ? (2 оноо)
- A. Хяс В. Бух дарах
C. Хөөрөгдөх D. Тулмаар хөөрөгдөх
E. Ийм арга байхгүй

9. Монгол нутаг дахь эртний хүмүүс ан амьтныг дүрслэхдээ ямарваа нэгэн байдлаар бусад амьтнаас ялгарах талыг нь илүү тод томруун дүрслэн харуулсаар ирсэн байна. Үүнийг түүхийн шинжлэх ухаанд хэрхэн нэрийддэг вэ? (3 оноо)
 А. Амьтны дүрст урлаг
 В. Амьтны загварчилсан дүрст урлаг
 С. Амьтныг гаж байдлаар дүрслэх урлаг
 D. Амьтныг хийсвэрлэн дүрслэх урлаг
 E. Амьтныг тод дүрслэх урлаг
10. НТӨ 57-55 онд Хүннү гүрэн нь ар, өвөр гэсэн хоёр хэсэгт хуваагдсан бөгөөд ийнхүү хуваагдахад нөлөө үзүүлсэн хамгийн гол хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Эзэн хаан нь таалал болсон
 В. Хүннүгийн язгууртнуудын дунд эрх мэдлийн төлөөх тэмцэл хүчтэй өрнөсөн
 С. Хятадад хүчирхэг улс байгуулагдсан
 D. Дунху нар хүчирхэгжсэн
 E. С ба D хариулт зөв
11. Монгол нутаг дахь анхны төрт улс болох Хүннү нарыг ямар бичиг үсэгтэй байсан гэж үздэг вэ? (1 оноо)
 А. Тамга, тэмдгээр баяжуулсан үсэг
 В. Мод сийлэн бичих Кэмү үсэг
 С. Уйгаржин монгол бичиг
 D. Түрэгийн Руни бичиг
 E. Их, бага бичиг
12. Хүннү гүрний үед холбогдол бүхий дараах дурсгалуудыг олдсон газар нутагтай нь тохируулна уу. (3 оноо)
 Хүннүгийн хэл хуур a. Булган аймгийн Бүрэгхангай сум
 Хүннүгийн шаньюйн тамга b. Төв аймгийн Батсүмбэр сум
 Бугын дүрс бүхий эсгий ширдэг c. Ховд аймгийн Үенч сум
 Ямаан усны хадны зураг d. Төв аймгийн Алтанбулаг сум
 А. 1a, 2b, 3c, 4d
 В. 1b, 2a, 3d, 4c
 C. 1d, 2a, 3c, 4b
 D. 1d, 2a, 3b, 4c
 E. 1c, 2a, 3b, 4d
13. Монгол нутагт төвлөрөн төрт улсаа байгуулж асан Уйгур улсын нийслэл болох Хар балгас буюу Орду Балык хотын туурь эдүгээ хаана байдаг вэ? (1 оноо)
 А. Архангай аймгийн Хотонт сумын нутагт
 В. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт
 С. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт
 D. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт
 E. Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт
14. Монголын түүхэнд холбогдол бүхий хэд хэдэн сурвалжийн мэдээг харьцуулан үзээд, Чингис хааны дээд өвөг болох Бөртэ чоныг хэдэн онд мэндэлсэн гэж үзсэн бэ? (1 оноо)
 А. 758 он
 В. 907 он
 С. 960 он
 D. 1035 он
 E. 1052 он
15. Хятан улс мөхсөний дараа нэлээд хэсэг нь нүүдэллэн Хар Хятан улсыг байгуулсан бөгөөд энэхүү улс нь хаана оршиж байсан бэ? (1 оноо)
 А. Европ тивд
 В. Цагаан хэрмийн цаана
 С. Байгал далайн орчим
 D. Дундад Азид
 E. Хөвсгөл нуурын орчим
16. “Монголын нууц товчоо”-нд “Зөөсөн хурааснаараа амьдардаг хүн” хэмээн гардаг. Дараах хариултын аль нь үүнд хамааралтай вэ? (2 оноо)
 А. Урт дурын хүн
 В. Харьяат зарц
 С. Харьяат хүн
 D. Өтөгү боол
 E. Онгу боол
17. Енисей мөрний эрэг орчмоос олдсон, “Чингисийн чулууны бичиг” хэмээн алдаршсан дурсгалыг хэдэн онд, юуны учир босгосон бэ? (2 оноо)
 А. 1206 онд Их Монгол улсыг байгуулсны учир
 В. 1224 онд Сартуул иргэнийг дайлан эзэлсний учир
 С. 1225 онд Есүнгэ мэргэнийг алдаршуулан
 D. 1227 онд Чингис хаан таалал болсны учир
 E. 1229 онд Өгөөдэй хаан ширээнд суусны учир
18. Чингис хааны байгуулсан Их Монгол улсын төрд зүтгэж байсан хүмүүсийг албан тушаалтай нь тохируулна уу. (3 оноо)
- | | | |
|--------------------------|-----------------------|-----------------------|
| 1. Төрийн их заргач | a. Шихихутаг | |
| 2. Төрийн бэхи | b. Үсүн өвгөн | |
| 3. Ван буюу ерөнхий сайд | c. Гоо Мухулай | |
| 4. Мал аж ахуйн сайд | d. Тодой чэрби | |
| 5. Төрийн заарин | e. Хөхөчү | |
| A. 1a, 2b, 3c, 4d, 5e | В. 1d, 2c, 3a, 4b, 5e | C. 1d, 2a, 3c, 4e, 5b |
| D. 1d, 2e, 3b, 4c, 5a | E. 1b, 2c, 3a, 4e, 5d | |

19. “Монголын нууц товчоо”-нд өгүүлсэнээр, Өгөөдэй хаан “... Энэ түрэмгий гайхал, хэний үгэнд орж ах хүнийг ам мэдэн доромжлох болов? Ганц муу өндөг ялзарчээ. Ах хүний өөдөөс эсэргүүцсэн ажээ. Харь хол газар хайгуулд явуулж, арван хурууны нь хумсыг ханзартал уул мэт хотыг эзлүүлэхээр урагш зүтгүүлье!” хэмээн сургамжлан өгүүлсэн байх бөгөөд энд хэнийг хэлж байна вэ? (2 оноо)
А. Бат В. Бүри С. Гүюг
D. Мөнх E. Аргасун
20. Персийн түүхч Рашид-Ад-Дин “Судрын чуулган” хэмээх зохиолоо бичихэд оролцсон Монгол түүхч аль нь вэ? (2 оноо)
А. Баян жанжин В. Баянтөмөр С. Эрдэмтэн Цагаан
D. Болд чинсан E. Монгол түүхч оролцоогүй
21. Монголын түүхэн дэх “Ноёдын үхэл чуулганд, Нохойн үхэл ганд” хэмээх сургамжит үг нь хэдэн онд болсон, түүхэн ямар үйл явдал дээр тулгуурлан бий болсон бэ? (3 оноо)
А. 1135 онд Татарууд Монголын хан Хабулыг алсан түүх
В. 1251 онд төрд тэрсэлсэн хэргээр Мөнх хаан олон хүмүүсийг алсан түүх
С. 1452 онд Эсэн тайш зүүн Монголын ноёдыг хядсан түүх
D. 1686 онд Халх Ойрадууд зөрчилдсөн чуулганы түүх
E. 1755-1758 оны Манжийг эсэргүүцсэн тэмцлийн түүх
22. Чингис хааны дараа орохуйц томоохон байлдан дагуулал хийж Дундад Ази, Туркестан, Ираны ихэнх хэсгийг өөртөө нэгтгэж, түүхэнд Тамерлан хэмээн алдаршсан хаан аль нь вэ? (2 оноо)
А. Мөнхтөмөр хаан В. Тогоонтөмөр хаан
С. Доголон Төмөр хаан D. Гүнтөмөр хаан
E. Өлзийтөмөр хаан
23. Монголын түүхэнд “Гар газар, хөл хөсөр байсан үе” хэмээн тэмдэглэсэн нь хэн гэдэг хааны төр барьж байсан үеийг хэлж байна вэ? (1 оноо)
А. Тайсун хаан В. Эсэн тайш хаан
С. Молон хаан D. Батмөнх даян хаан
E. Түмэн засагт хаан
24. Батмөнх даян хааны отгон хөвгүүн Гэрсэнз хунтайжийн долоон хөвгүүдийн эзэмшил нутаг нь XVI зууны сүүл XVII зууны эхэн үед Халхын хэдэн аймаг, хэдэн хошуунд хуваагдаж байсан бэ? (2 оноо)
А. Хоёр аймаг, Зургаан хошуу В. Гурван аймаг, Долоон хошуу
С. Гурван аймаг, Арван хошуу D. Дөрвөн аймаг, Гучин дөрвөн хошуу
E. Дөрвөн аймаг, Наян зургаан хошуу
25. 1646 оны хавар Манжийн ноёрхлыг эсэргүүцэн Халхад дагаар ирсэн Өвөр Халхын ноён аль нь вэ? (3 оноо)
А. Эрх чин ван Тод В. Чин ван Абунай
С. Сөнидийн Тэнгис ван D. Хорчины Ууба тайж
E. Жарудын Анан тайж
26. Дараах түүхэн сурвалжуудын алийг нь Лувсанданзан гүүш 1634 онд хуйлуулан зохиосон бэ? (2 оноо)
А. Эртний хаадын үндэслэсэн төрт ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч нэрт судар оршивой
В. Их Монгол улсын хаадын үндсэн Алтан товч нэрт судар оршивой
С. Хаадын үндэсний хураангуй Алтан товч нэрт судар оршивой
D. Эртний монголын хаадын үндэсний их Алтан товч нэрт судар оршивой
E. Нэгэн сурвалжийн дөрвөн өөр нэр байна
27. XVII зуунд хуралдсан ноёдын чуулганыг болсон газар нутагтай нь тохируулна уу. (3 оноо)
1. 1640 оны чуулган a. Заг Байдрагийн Хүрэн бэлчир
2. 1686 оны чуулган b. Өвөр Монголын нутаг Долоннуур
3. 1689 оны чуулган c. Ил Тарвагатайн Улаан бураа
4. 1691 оны чуулган d. Өвөр Монголын нутаг Ар элстэй
А. 1a, 2b, 3c, 4d В. 1c, 2a, 3d, 4b С. 1d, 2a, 3c, 4b
D. 1d, 2a, 3b, 4c E. 1b, 2c, 3a, 4d
28. Зүүнгар хаант улсыг хэн, хэдэн онд үндэслэн байгуулсан бэ? (1 оноо)
А. 1452 онд Эсэн тайш хаан В. 1620 онд Очирт сэцэн хан
С. 1634 онд Эрдэнэбаатар хунтайж D. 1676 онд Галдан бошгот хаан
E. 1689 онд Цэвээнравдан хаан
29. 1755-1758 оны зэвсэгт тэмцэл амжилтгүй болсон шалтгаанд аль хариулт нь хамаарах вэ? (2 оноо)
А. Монголчууд нэгдмэл байж чадаагүй В. Манж нар тус тусад нь цохисон
С. Монголын зарим ноёд урвасан D. Манж нар их цэргийн хүчээр нухчин дарсан
E. Бүгд хамааралтай

30. Монголчууд бичиг үсгийн арвин их түүхтэй ард түмэн мөн бөгөөд дундад үеийн түүхэндээ нэлээд хэдэн үсэг зохион хэрэглэж иржээ. Тэрхүү бичиг үсгийг зохиогчтой нь тохируулна уу. (3 оноо)
1. Дөрвөлжин үсэг a. Зая бандида Намхайжамц
 2. Али гали галиг үсэг b. Пагва лам Лодойжалцан
 3. Тод үсэг c. Харчины Аюуш гүүш
 4. Соёмбо үсэг d. Агваан лам
 5. Вагиндрагийн үсэг e. Өндөр гэгээн Занабазар
- A. 1a, 2b, 3c, 4d, 5e B. 1d, 2c, 3a, 4b, 5e C. 1d, 2a, 3c, 4e, 5b
D. 1d, 2e, 3b, 4c, 5a E. 1b, 2c, 3a, 4e, 5d
31. “Тамгатай хутагт” хэмээх тодорхойлолтонд аль хариулт нь нийцэх вэ? (2 оноо)
- A. Шавь захирах эрхтэй
 - B. Угсаа гарал сайтай лам нар
 - C. Хүрээний хутагт лам
 - D. Түвдээс ирсэн хутагт лам
 - E. Манжийн талыг илэрхий баримталсан лам
32. 1911 онд Богд хаан цэргийн яамны сайдаар хэнийг томилсон бэ? (1 оноо)
- A. Да лам Цэрэнчимэд
 - B. Түшээ гүн Чагдаржав
 - C. Эрдэнэ ван Намсрай
 - D. Хошой чин ван Ханддорж
 - E. Засаг гүн Гомбосүрэн
33. 1913 онд Монгол улсын анхны сэтгүүлийг Ж.Цэвээн тэргүүтэй дэвшилтэт үзэл бүхий сэхээтнүүд үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь ямар нэртэйгээр гарсан бэ? (2 оноо)
- A. Нийслэл хүрээний сонин бичиг
 - B. Шинэ толь
 - C. Оюунтүлхүүр
 - D. Орчлонгийн сав шим
 - E. Алтан дэвтэр
34. 1919 онд Монголын авгономийг устгах хэрэг явдалд Монголын зүгээс хэн гэдэг улс төрч идэвхийлэн оролцсон бэ? (2 оноо)
- A. Сайн ноён хан Намнансүрэн
 - B. Да лам Цэрэнчимэд
 - C. Шанзодба да Бадамдорж
 - D. Жүн ван Ширмэндамдин
 - E. Монгол хүн оролцоогүй
35. 1921 оны Ардын Ардчилсан хувьсгалд тэргүүлэх үүрэгтэй оролцсон Монгол Ардын Нам дараах он цагийн алинд нь байгуулагдсан бэ? (1 оноо)
- A. 1920 оны 6-р сарын 15
 - B. 1920 оны 6-р сарын 25
 - C. 1921 оны 3-р сарын 1
 - D. 1921 оны 3-р сарын 18
 - E. 1921 оны 7-р сарын 11
36. Тангарагийн гэрээнд улс төрийн талаар Богд хааныг хэрхэн заасан байдаг вэ? (1 оноо)
- A. Богд хаан болох тул ямар нэг хориг байхгүй
 - B. Шарын шашны Богд эзэн тул улс төрийн хэрэгт холбогдолгүй
 - C. Бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино
 - D. А ба С хариулт зөв
 - E. Зөв хариулт алга
37. 1923 оноос аймаг хошуудын хуучин нэрийг халан уул усны нэрээр нэрлэх болсон байна. Энэ үед хуучны Халхын Сайн ноён хан аймгийг ямар нэрээр нэрлэх болсон бэ? (2 оноо)
- A. Хан Хэнтий уулын аймаг
 - B. Богд хан уулын аймаг
 - C. Цэцэрлэг мандал уулын аймаг
 - D. Хантайшир уулын аймаг
 - E. Чандмань уулын аймаг
38. 1929-1931 оны Зүүнтний нугалаа завхрал нь Монголын түүхэнд ямар сургамжийг үлдээсэн бэ? (3 оноо)
- A. Зөвлөлт засгийн бодлогыг шууд хуулбарлан дуурайх нь буруу гэдэг
 - B. Нударган нэрээр чинээлэг иргэдийн хөрөнгийг хураах нь буруу гэдэг
 - C. Шашин шүтэх эс шүтэх эрхийг нь хаан боогдуулах нь буруу гэдэг
 - D. Монголд Бүгд найрамдах засаглал тохирохгүй гэдэг
 - E. А, В, С хариултууд зөв
39. Доорх аймгуудаас одоогийн аль аймгууд байгуулагдсан болохыг тохируулна уу. (3 оноо)
1. Чандмань уулын аймаг a. Архангай
 2. Хан Хэнтий уулын аймаг b. Төв
 3. Богд хан уулын аймаг c. Завхан
 4. Цэцэрлэг мандал уулын аймаг d. Хэнтий
 5. Хантайшир уулын аймаг e. Увс
- A. 1a, 2b, 3d, 4c, 5e B. 1b, 2c, 3a, 4e, 5d C. 1d, 2e, 3a, 4b, 5c
D. 1e, 2d, 3b, 4a, 5c E. 1e, 2d, 3c, 4b, 5a

40. БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай Монголын бүх ард түмний санал хураалт дараах он цагийн алинд нь болсон бэ? (3 оноо)
А. 1940 оны 6-р сар 20
В. 1941 оны 1-р сар 22
С. 1942 оны 10-р сар 20
D. 1945 оны 10-р сар 20
E. 1946 оны 10-р сар 26
41. 1939 оны Халх голын дайнд гавьяа байгуулж, БНМАУ-ын баатар цолоор ямар хүмүүс шагнагдсан бэ? (1 оноо)
А. Л.Аюуш, Л.Чогдон, Д.Данзанваанчиг
В. Ц.Олзвой, С.Дампил, Т.Дүүдэй
С. Л.Аюуш, Л.Гэлэгбаатар, Л.Дандар
D. Ц.Олзвой, М.Экей, Л.Гэлэгбаатар
E. С.Дампил, Д.Данзанваанчиг, Л.Дандар
42. Дараах өгөгдлүүдийн аль нь зөв илэрхийлэл вэ? (3 оноо)
А. 1945 оны V сарын 1-н; Герман улс бууж өгөв
В. 1945 оны VIII сарын 8-н; ЗХУ Японд дайн зарлав
С. 1945 оны VIII сарын 10-н; БНМАУ Японд дайн зарлав
D. 1945 оны X сарын 15-н; БНМАУ-д бүх нийтийн санал хураалт явагдав
E. 1946 оны I сарын 3-н; Хятадын гоминданы засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв
43. 1946 - 1948 онд Хятадын зүгээс Монголын аль хэсгээр зэвсэгт халдлага хийх болсон бэ? (1 оноо)
А. Монголын зүүн хилийн Халх гол орчмоор
В. Монголын зүүн өмнөд хилийн Дарьганга орчмоор
С. Монголын зүүн хилийн Булан дэрс орчмоор
D. Монголын өмнөд хилийн Гашуун сухайт орчмоор
E. Монголын баруун өмнөд хилийн Байтаг Богд орчмоор
44. Нэг хүнийг тахин шүтэхэд шууд нөлөөлсөн хүчин зүйлд аль хариулт нь хамаарах вэ? (1 оноо)
А. ЗХУ-н дээд удирдлага Коминтерний зүгээс БНМАУ-ын дотоод хэрэгт шууд оролцсон
В. Улс төр, эдийн засгийн талаар бие даасан бодлого явуулж чадахгүй байсан
С. Боловсон хүчний нөөц, мэргэжлийн улс төрчид хангалтгүй байсан
D. Улс орны хөгжил сул байсан
E. А, В, С хариултууд хамаарна
45. Хөдөө Аж Ахуйн Нэгдлийн үлгэрчилсэн дүрмийг хэдэн онд хуралдсан аль хурал дээр баталсан бэ? (2 оноо)
А. 1934 онд хуралдсан Улсын сайн малчдын анхдугаар зөвлөлгөөн
В. 1942 оны хуралдсан Улсын сайн малчдын II зөвлөлгөөн
С. 1948 онд хуралдсан Улсын ба ХАА-н сайчуудын III зөвлөлгөөн
D. 1955 онд хуралдсан Улсын тэргүүний малчдын IV зөвлөлгөөн
E. 1960 онд хуралдсан ХААН-ийн сайчуудын I зөвлөлгөөн
46. Монголчууд 1960 оны 1-р сараас Цагаан сарыг ямар нэрээр тэмдэглэх болсон бэ? (2 оноо)
А. Малчдын цагаан сар
В. Нэгдэлчдийн баяр
С. Монголын цагаан сар
D. Хаврын баяр Цагаан сар
E. С ба В хариултууд зөв
47. 1968 оны Мехикогийн олимпоос Монголын анхны медалийг авсан тамирчид аль нь вэ? (1 оноо)
А. Ж.Мөнхбат мөнгө, Т.Артаг, Х.Баянмөнх, Ч.Дамдиншарав хүрэл
В. Х.Баянмөнх, Ж.Мөнхбат мөнгө, Ц.Дамдин, З.Ойдов хүрэл
С. З.Ойдов, Х.Баянмөнх мөнгө, Артаг, Д.Сэрээтэр хүрэл
D. З.Ойдов мөнгө, С.Цэрэн, Ч.Дамдиншарав, Х.Баянмөнх хүрэл
E. Ж.Мөнхбат мөнгө, Т.Артаг, Ч.Дамдиншарав, Д.Сэрээтэр хүрэл
48. Монголын мал аж ахуйн салбар дахь малын үүлдэр угсааг зөв тохируулна уу. (3 оноо)
1. Адуу а. Сартуул
2. Тэмээ b. Халх голын талын улаан
3. Үхэр c. Тулман хөхт
4. Хонь d. Тэсийн гол
5. Ямаа e. Ханын хэцийн хүрэн
А. 1b, 2c, 3d, 4e, 5a В. 1c, 2b, 3e, 4a, 5d С. 1d, 2a, 3b, 4c, 5e
D. 1a, 2e, 3c, 4d, 5b E. 1d, 2e, 3b, 4a, 5c
49. Болгар улсын тусламжтайгаар нэхий, нэхий эдлэлийн үйлдвэрийг хаана байгуулсан бэ? (2 оноо)
А. Улаанбаатар хот
В. Эрдэнэт хот
С. Дархан хот
D. Чойр хот
E. Хархорин хот

50. Монголын түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн, “Чингис хааны үед бүх монгол аймаг угсаатан нэгэн төрийн жолоонд нэгдмэл байсан, хожим монгол буурах үед тэдний хагас нь Хятадын мэдэлд, хагас нь Оросын мэдэлд орсон бөгөөд одоо бүх Монгол овог, аймгууд нэгдэх тохиромжтой үе ирээд байна” хэмээх энэ үг хэдэн оны ямар түүхэн хэрэг явдалтай холбогдолтой вэ? (2 оноо)
- | | |
|--|--|
| А. 1691 оны Долоннуурын чуулган | В. 1755-1758 оны зэвсэгт тэмцэл |
| С. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал | Д. 1919 оны Нармай Монголын үзэл санаа |
| Е. 1921 оны Ардын ардчилсан хувьсгал | |

2009 оны Монгол улсын түүхийн хичээлийн даалгаврын түлхүүр

Хувилбарууд			
№	А	С	Е
1	B	B	A
2	C	A	C
3	A	E	B
4	C	D	A
5	D	E	D
6	C	D	D
7	C	D	D
8	E	C	B
9	D	A	B
10	B	C	B
11	E	E	A
12	C	B	D
13	C	B	A
14	C	A	A
15	D	C	D
16	C	A	A
17	C	A	C
18	C	B	A
19	D	C	C
20	D	C	D
21	C	A	C
22	B	E	C
23	B	E	D
24	E	C	B
25	D	E	C
26	C	B	A
27	C	E	B
28	D	E	D
29	B	E	E
30	E	E	E
31	C	A	A
32	D	B	E
33	E	E	B
34	C	D	C
35	D	E	B
36	D	C	B
37	E	B	C
38	A	A	E
39	E	B	D
40	D	D	D
41	E	A	D
42	E	B	C
43	A	B	E
44	D	E	E
45	D	D	D
46	C	D	B
47	C	B	E
48	D	C	E
49	E	C	C
50	C	B	D